



Хууль зүйн мэдээ

www.nli.gov.mn

Хууль зүйн мэдээ сонин

2023.10.31

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН САЛБАРЫН ЗАРИМ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХИЙГ УРЬЖ БАЙНА



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

УРЬЖ БАЙНА



ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН
САЛБАРЫН ЗАРИМ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ
ХИЙХ

Тавигдах шаардлага

- Судлаач нь хууль зүйн ухааны магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх /Багаар ажиллах тохиолдолд судалгааны багийн ахлагч докторын зэрэгтэй байх/,
- Багаар ажиллах тохиолдолд 2 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй байна
- Сонгон авсан сэдвийн талаар өмнө нь судалсан, тус чиглэлээр мэргэшин ажилласан туршлагатай бол давуу тал болно.

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН САЛБАРЫН ЗАРИМ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХИЙГ УРЬЖ БАЙНА

Хууль зүйн үндэсний төлөөллийн харилцаан дахь тус чиглэлээр мэргэшин хүрээлэн нь хууль итгэл үнэмшлийг хамгаалах ажилласан туршлагатай тогтоомжийн төлөв зохицуулалт, түүний хэрэглээ бол давуу тал болно. байдал, хандлага, хэрэгцээ, Судалгааг Засгийн газрын шаардлагыг урьдчилан 2016 оны 59 дүгээр **Бүрдүүлэх баримт бичиг:** тандан судлах, хуулийн тогтоолын зургаадугаар Судлаач бүр боловсрол, хэрэгжилтийн үр дагаварт хавсралтаар баталсан “Хууль Судлаач бүр боловсрол, үнэлгээ хийх, эрдэм тогтоомжийн хэрэгжилтийн мэргэшил, ажлын туршлагыг шинжилгээний зөвлөмж, үр дагаварт үнэлгээ хийх харуулах танилцуулга /CV/- аргачлал боловсруулах, аргачлал”-ын дагуу хийнэ. ыг гүйцэтгэсэн судалгааны ажлын жагсаалтын хамт хавсаргасан байна. Судалгааны мэдүүлгийн үнийн саналыг ирүүлэх. Хамтран ажиллах хүсэлтэй судлаачид дээр дурдсан баримт бичгийг 2023 оны 11 дүгээр сарын 03-ны Баасан гарагийн 15 цагт багтаан info@legalinstitute.mn цахим хаягаар ирүүлнэ үү. Холбоо барих утас: 11-323833

Тавигдах шаардлага

Судлаач нь хууль зүйн ухааны магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх /Багаар ажиллах тохиолдолд судалгааны багийн ахлагч докторын зэрэгтэй байх/, Багаар ажиллах тохиолдолд 2 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй байна Сонгон авсан сэдвийн Холбоо барих утас: 11-323833

Иргэнийн хуулийн талаар өмнө нь судалсан,

Иргэн танд хууль зүйн зөвлөгөө,
мэдээллийг энгийн утасны тарифаар
хүргэх утас:

1800-1202



“ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ”-ЫН ТАЛААР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Хүний эрхийн Үндэсний Комисс, Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр “Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц”-ын талаар сургалт зохион байгууллаа. Сургалтад 34

өмгөөлөгч хамрагдлаа.

Сургалтад ХЭҮК-ын Сургалт, сурталчилгааны хэлтсийн дарга Х.Цэцгээ “Хүний эрхийн Олон Улсын гэрээ, конвенц”-ын ойлголт, Хүнийг хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенц сэдвээр хичээл заав. Тус сургалтын

зорилго нь өмгөөлөгч нарт мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Олон Улсын холбогдох гэрээ, конвенцыг ашиглах, үндэсний хууль тогтоомж дахь зохих зүйл заалт, зохицуулалтыг эдгээртэй уялдуулж хэрэглэх талаар зохих ойлголт, мэдлэг олгох юм.



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН НЬ ДАРААХ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛТАН ШАЛГАРУУЛЖ АВНА

Нэгж, ажлын байр: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн зохицуулагч, программист

Орон тоо: 1

Ажлын тодорхойлолт:

- Байгууллагын компьютер, техник хэрэгслийн хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангаж ажиллах, тоо бүртгэл хөтлөх;
- Интернетийн холболт болон байгууллагын дотоод сүлжээний хэвийн ажиллагааг хангах, хяналт тавих;
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн өдөр тутмын сервисийг хариуцах, мэдээлэл оруулагч нарт зөвлөгөө өгөх;
- Шаардлагатай тохиолдолд Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн эрх зүйн актын системчлэл, ангилал, мэдээлэл оруулах зэрэг ажилд оролцох;
- Иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага тэдгээрт зориулсан эрх

зүйн сурталчилгааны ажилд оролцох;
- Байгууллагын цахим хуудасны хэвийн үйл ажиллагааг хангах, хөгжүүлэлт хийх;
- Системд шаардлагатай бусад мэдээ, мэдээллийг бэлтгэх;
- Байгууллагын мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавих;
- Мэдээллийн технологийн сүүлийн үеийн шийдлүүдийг судалж, шинэ технологи нэвтрүүлэх;
Байгууллагын ажилтнуудад мэдээллийн технологийн чиглэлээр зөвлөгөө өгөх.

Ажлын байранд тавигдах ерөнхий шалгуур:

- Мэдээллийн технологи, программ хангамж, сүлжээ, өгөгдлийн сан, холбогдох чиглэлээр бакалавр болон түүнээс

дээш зэрэгтэй байх;
- Компьютерийн техник болон програм хангамжийн өндөр мэдлэгтэй, компьютерийн хэрэглээний програм хангамжийг бүрэн ашиглах чадвар, туршлагатай байх;
- Асуудлыг бүрэн гүйцэд судалж, саналын хувилбараас аль оновчтойг нь сонгох, түүнийгээ бичгээр товч тодорхой, үндэслэлтэй илэрхийлэх чадвартай байх;
- Гадаад хэлний зохих мэдлэгтэй байх;
- Багаар ажиллах чадвартай, харилцааны соёлтой.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орохыг хүссэн өргөдөл,
- Дипломын хуулбар,
- Төрийн албан хаагчийн анкет,
- 3×4 хэмжээтэй 4 хувь цээж зураг,
- Хувь хүний намтар

2024 оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхлэх хуулиуд

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ ?

ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГТ ЗОРИУЛАВ

ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Гэрлэхэд харшлах ямар шалтгаанууд байдаг вэ?

Гэрлэхийг хүсэгчид Гэр бүлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар дараах **харшлах шалтгаануудтай бол гэрлэхийг хориглоно**. Үүнд:

1. Хэрэв таны өмнөх гэрлэлт хүчинтэй байгаа бол;
2. Гэрлэгчид хоёулаа, эсхүл хэн нэг нь 18 насанд хүрээгүй бол;
3. Төрөл, садангийн хүмүүс хоорондоо гэрлэх;

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРНУЛТ

ЦУВРАЛ 99

ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Гэрлэлтээ бүртгүүлэхдээ ямар баримт бичиг бүрдүүлэх шаардлагатай вэ?

Гэрлэхийг хүсэгчид засаг захиргааны нэгж харгалзахгүй доорх баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

- Тус тусдаа гаргасан өргөдөл;
- Гэрлэхийг хүсэгчдийн иргэний үнэмлэх, эсхүл гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, эсхүл паспортыг орлох баримт бичиг;
- Гэр бүлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан гэрлэхийг хүсэгчдийн эрүүл мэндийн шинжилгээний бичиг.

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРНУЛТ

ЦУВРАЛ 102

ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛИАС

ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Манай нөхөр Англи улсын иргэн. Бид гэрлэлтээ Англи улсад 2005 онд бүртгүүлж тэнд одоог хүртэл амьдарч байна. Эх орондоо очвол гэрлэлт хүчинтэй юу?

Монгол Улсын гэр бүлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан **харшлах шалтгаангүй бол** гадаад улсад гэр бүл болсон ч гэсэн эх оронд тань таны бүртгэл хүчинтэйд тооцогдоно.

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРНУЛТ

ЦУВРАЛ 100

ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Гэрлэлтээ бүртгүүлэхдээ заавал гэрч байлцуулах ёстой юу? Мөн гэрч нь төрсөн ах дүү, хамаатан садан нь байх үү?

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дах хэсэгт **"Гэрлэсний бүртгэлийг хөтлөхдөө гэрлэхийг хүсэгчдийг гэрчийн хамт байлцуулах бөгөөд гэрчээр 18 нас хүрсэн хүнийг оролцуулна"** гэж зааснаар заавал гэрч байлцуулах ба гэр нь төрөл садангийн хүн байх шаардлагагүй.

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРНУЛТ

ЦУВРАЛ 101

ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ ТУХАЙ

ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБА

Ямар тохиолдолд цэргийн албыг мөнгөн хэлбэрээр орлуулан хаах боломжтой вэ?

Цэргийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дах хэсэгт хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн цэргийн алба хаагаагүй иргэн хуулиар тогтоосон хугацаат цэргийн албыг биеэр хаагаагүйн төлөө **мөнгөн төлбөрийн хэлбэрээр цэргийн дүйцүүлэх албыг** орлуулан хаана.

Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРНУЛТ ЦУВРАЛ 95

ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБА

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж болох үү?

Болно. Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт **Монгол Улсын иргэн 18-25 насны** цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн **шашин шүтлэг, ёс зүйн шалтгаанаар** цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж болно. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хугацаа 24 сар байна.

Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРНУЛТ ЦУВРАЛ 96

ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБА

Мөнгөн төлбөрийн хэмжээ хэд байдаг вэ?

2023 онд Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг **11,935,308** (арван нэгэн сая есөн зуун гучин таван мянга гурван зуун найман) **төгрөгөөр** тогтоосон.

Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРНУЛТ ЦУВРАЛ 97

ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБА

Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийг хөнгөлөх боломжтой юу?

Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 6 дах хэсэгт Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээ нь хуулийн дагуу цэргийн албанаас чөлөөлөгдсөн жилд харгалзуулан долоон жилд 14 хувь, зургаан жилд 28 хувь, таван жилд 32 хувь, дөрвөн жилд 46 хувь, гурван жилд 60 хувь, хоёр жилд 74 хувь, нэг жилд 88 хувь, чөлөөлөгдөж байгаагүй бол 100 хувь байна.

Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРНУЛТ ЦУВРАЛ 98

Иргэн танд хууль зүйн зөвлөгөө, мэдээллийг энгийн утасны тарифаар хүргэх утас:

1800-1202



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 21 дэх жилдээ эрхлэн гаргаж буй хууль зүйн эрдэм шинжилгээ, онол, практикийн улирал тутмын “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2023 оны 4 дүгээр улирлын болон англи хэл дээрх тусгай дугаарт хуульч, эрдэмтэн, багш, судлаач Та бүхнийг эрдэм шинжилгээний бүтээл нийтлүүлэхийг урьж байна.



“ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС”

сэтгүүлд бүтээл хүлээн авч байна

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 21 дэх жилдээ эрхлэн гаргаж буй хууль зүйн эрдэм шинжилгээ, онол, практикийн улирал тутмын “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2023 оны 4 дүгээр улирлын болон англи хэл дээрх тусгай дугаарт хуульч, эрдэмтэн, багш, судлаач Та бүхнийг эрдэм шинжилгээний бүтээл нийтлүүлэхийг урьж байна.

Сэтгүүлд ирүүлэх өгүүлэл, нийтлэл нь “ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС” сэтгүүлийн журамд заасан эрдэм шинжилгээний бүтээлд тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна. (Сэтгүүлийн журмыг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн цахим хуудаснаас орж үзнэ үү.)

Жич: Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь эрдэм шинжилгээний багц цагт тооцогдоно.



Бүтээл хүлээн авах хугацаа:

Дөрөвдүгээр улирлын дугаарт нийтлэх бүтээлийг	X/31 хүртэл
Англи хэл дээрх тусгай дугаарт нийтлэх бүтээлийг	X/31 хүртэл

Хянан магадлалын хураамж 50,000 төгрөг



lawjournal@legalinstitute.mn



99247620

ИРГЭН ТАНД ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЛИЙГ ЭНГИЙН УТАСНЫ ТАРИФААР ХҮРГЭХ УТАС:



08:30-17:30

1800-1202

Эрх зүйн боловсролыг иргэн бүрд

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ

"НИЙТИЙН МЭДЭЭЛЭЛ" гэж нийтийн мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд цуглуулсан, боловсруулсан, ашиглаж байгаа өгөгдлийн бүрдлийг хэлнэ.

Нийтийн мэдээллийг **НЭЭЛТЭЙ, ХЯЗГААРЛАЛТАЙ, ХААЛТТАЙ** гэж ангилна.

✓ Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээллийг **НЭЭЛТЭЙ МЭДЭЭЛЭЛ** гэж үзнэ.

✓ Танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг **ХЯЗГААРЛАЛТАЙ МЭДЭЭЛЭЛ** гэж үзнэ.

✓ Хуульд хаалттай байхаар заасан, эсхүл төрийн нууцад хамаарах мэдээллийг **ХААЛТТАЙ МЭДЭЭЛЭЛ** гэж үзнэ.

НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ



ХУУЛЬ ЗҮЙН
ТНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХЯЗГААРЛАЛТАЙ МЭДЭЭЛЭЛД дараах мэдээлэл хамаарна:

- 1 Хуульд өөрөөр заагаагүй бол **гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад цуглуулсан мэдээлэл;**
- 2 Төрийн хяналт шалгалтын явцад болон шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд цуглуулсан мэдээлэл;
- 3 Нээлттэй байлгах нь соёлын хосгүй үнэт өвд аюул учруулж болзошгүй мэдээлэл;
- 4 Хуульд заасан бусад.

ХЭСЭГЧЛЭН АВАВ



ХУУЛЬ ЗҮЙН
ТНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

НЭЭЛТЭЙ МЭДЭЭЛЭЛ

Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана. Жишээ нь:

- ✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн үлсын комиссын дүгнэлт;
- ✓ Тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт олгосон газар ашиглах гэрчилгээ, байгуулсан гэрээ, газар ашигласны төлбөр төлөлтийн байдал;
- ✓ Улс төрийн намын дүрэм, гишүүнчлэл, хөрөнгө, түүнд өгсөн хандивын мэдээлэл;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуртийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувиулах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл.

ХААЛТТАЙ МЭДЭЭЛЭЛД дараах мэдээлэл хамаарна:



Төрийн нууцад хамааруулсан мэдээлэл;

"Төрийн нууц" гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үргэдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг хэлнэ.



Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12.3-т заасан мэдээлэл



Хуульд заасан бусад мэдээлэл.

Хаалттай мэдээлэлтэй хуульд заасан үндэслэл, журмын дагуу танилцаж, ашиглаж, ил болгоно.

2024 оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхлэх хуулиуд

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/